



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 11 сарын 14 өдөр

Дугаар A/422

Улаанбаатар хот

Г

Г

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 2 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг холбогдох газар, хэлтэс, харьяа эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, ерөнхий захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д. Очирбат)-д даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 448 дугаар тушаал, 2014 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 283 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



081357

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 11 сарын 14-ны өдрийн  
*А/422* дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмыг Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-ны харьяа эрүүл мэндийн байгууллага, аймаг/нийслэлийн Эрүүл мэндийн газар (ЭМГ) (цаашид “Эрүүл мэндийн байгууллага” гэх)-ын үйл ажиллагаа, Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэр, Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгавар (цаашид “Холбогдох эрх зүйн баримт бичиг” гэх)-ын хэрэгжилтийг зохион байгуулах, явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэхэд мөрдөнө.

1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-ний зорилго нь төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг сайжруулж, хэрэгжилт, хариуцлагыг нэмэгдүүлж бэхжүүлэх, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийг сайжруулахад оршино.

1.3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь холбогдох хууль, тогтоомж, энэхүү журмыг үндэслэн өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудад ХШҮ хийх журмыг батлан мөрдөнө.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим

2.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- 2.1.1. шударга, хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус байх;
- 2.1.2. хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа, явц нээлттэй, тэдгээрээс гарсан тайлан, дүгнэлт нь ил тод байх;
- 2.1.3. үр дүнд чиглэсэн байх;
- 2.1.4. тоо баримт, судалгаа, албан ёсны мэдээлэл зэрэг нотолгоонд тулгуурласан байх;
- 2.1.5. хяналт-шинжилгээг тасралтгүй, үнэлгээг тодорхой үе шаттай, тогтмол хийдэг байх;
- 2.1.6. хэрэглэгч, сонирхогч талуудын оролцоог хангасан байх.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

3.1. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн болон тусгайлсан гэсэн 2 төрлийн ХШҮ хийнэ.

3.1.1. Гүйцэтгэлийн ХШҮ нь дараах хүрээг хамрана. Үүнд:

3.1.1.1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагч (Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, ЭМЯ-ны харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн ерөнхий захидал)-тай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн байдал;

3.1.1.2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвортой суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт;

3.1.1.3. Байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа;

3.1.1.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт;

3.1.1.5. Хэрэглэгчийн үнэлгээ.

3.1.2. Тусгайлсан ХШҮ нь дараах хүрээг хамрана. Үүнд:

3.1.2.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт дараах баримт бичиг хамаарна:

3.1.2.1.1. Монгол Улсын хууль;

3.1.2.1.2. Улсын Их Хурлын тогтоол;

3.1.2.1.3. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол;

3.1.2.1.4. Ерөнхийлөгчийн зарлиг;

3.1.2.1.5. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр;

3.1.2.1.6. Засгийн газрын тогтоол;

3.1.2.1.7. Ерөнхий сайдын захирамж;

3.1.2.1.8. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл;

3.1.2.1.9. Засгийн газрын албан даалгавар.

3.1.2.2. Бодлогын баримт бичигт дараах баримт бичиг хамаарна:

3.1.2.2.1. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030;

3.1.2.2.2. Төрөөс баримтлах бодлого;

3.1.2.2.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;

3.1.2.2.4. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр;

3.1.2.2.5. Үндэсний хөтөлбөр;

3.1.2.2.6. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;

3.1.2.2.7. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр.

3.1.2.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ:

3.1.2.3.1. Эмнэлзүйн удирдамж, зааврын хэрэгжилтийн байдал;

3.1.2.3.2. Зайлшгүй шаардлагатай болон амин чухал эмийн хангамж, эмийн чанар, аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ;

3.1.2.3.3. Эмчилгээ, оношилгооны шинэ арга, дэвшилтэт технологийг практикт нэвтрүүлж, эрүүл мэндийн болон эдийн засгийн үр дүнг тооцсон байдал;

3.1.2.3.4. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээтэй холбоотой халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн;

3.1.2.3.5. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээтэй холбоотой гомдлын шийдвэрлэлт;

3.1.2.3.6. Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусlamж, үйлчилгээний талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн.

#### 3.1.2.4. Байгууллагын удирдлага, хөгжил:

3.1.2.4.1. Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн;

3.1.2.4.2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн;

3.1.2.4.3. Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, онцгой байдлын үеийн бэлэн байдал хангах, хариу арга хэмжээний болон нөхөн сэргээх үеийн төлөвлөгөө, хэрэгжилтийн байдал, тухайн жилд зохион байгуулсан бэлэн байдлын сургалтын тоо;

3.1.2.4.4. Байгууллагын эрсдлийн удирдлага, эрсдэл бууруулах төлөвлөгөө, хэрэгжилтийн байдал;

3.1.2.4.5. Байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран ажилласан байдал, хамтын гэрээний хэрэгжилтийн үр дүн;

3.1.2.4.6. Тухайн байгууллагаас хэрэгжүүлж буй судалгааны хэрэгжилт, календарчилсан төлөвлөгөөний биелэлт;

3.1.2.4.7. Байгууллагын гадаад хамтын ажиллагаа, гадаадын зээл, тусlamжаар хэрэгжүүлж буй төслийн үр дүн;

3.1.2.4.8. Байгууллагын хөгжил, соёлын талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн.

#### 3.1.2.5. Мэдээллийн удирдлага:

3.1.2.5.1. Статистик мэдээллийн үнэн бодит, шуурхай байдал, мэдээний чанар;

3.1.2.5.2. Байгууллагын цахим хуудасны тогтмолжсон байдал;

3.1.2.5.3. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд мэдээллийн технологийн зохистой хэрэглээг төлөвшүүлсэн байдал, үр дүн;

3.1.2.5.4. Эрүүл мэндийн мэдээлэл, мэдээллийн технологийн талаарх холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн байдал, үр дүн.

**Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага,  
зохион байгуулалт**

1.1. Эрүүл мэндийн байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий дотоод хяналтын нэгж, эсхүл ажилтантай байна.

1.2. Эрүүл мэндийн яам нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүргийг хариуцна.

1.3. Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгж (ЭМЯ-нд Төрийн захиргааны удирдлагын газар) бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Төрийн албан хаагч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж өгөх үүрэгтэй.

1.4. Тухайн байгууллагын дотоод хяналтын нэгж байгууллагын чиг үүрэг, бүтэц, орон тооны хязгаарт нийцсэн үйл ажиллагаа явуулахад хүрэлцэхүйц бүрэлдэхүүнтэй байна.

1.5. Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчид тавих шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан хүнийг бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан тушаалд томилно:

1.5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр болон эрүүл мэндийн салбарт гурваас доошгүй жил ажилласан туршлагатай байх;

1.5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр гадаад, дотоодын сургалтад хамрагдсан байх;

1.5.3. Баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх.

**Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтны эрх, үүрэг**

5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан хаагч нь дараах эрхтэй байна:

5.1.1. байгууллагын дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны мэдээлэлтэй танилцах;

5.1.2. хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээлэл, баримт, материалыг холбогдох нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

5.1.3. хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтээр зөвлөмж өгөх, өгсөн зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжлах;

5.1.4. хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан хаагч нь дараах үүрэгтэй байна:

5.2.1. хууль тогтоомж, төрийн албаны ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах;

5.2.2. хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад олж авсан баримт, мэдээллийн нууцыг чанд хадгалж зөвхөн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд ашиглах;

5.2.3. хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах;

5.2.4. мэргэжил, мэдлэг, чадвараа тогтмол дээшлүүлэн хөгжүүлэх.

#### Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт, төрөл

6.1. Эрүүл мэндийн байгууллага нь жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг батална. Энэхүү төлөвлөгөө нь тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн төлөвлөгөө байж болно. Төлөвлөгөөнд зорилго, зорилт, хамрагдах байгууллага, нэгж, хэрэгжүүлэх хугацаа, зардал, хамтран оролцох байгууллага зэргийг тусгана.

6.2. Үнэлгээний зорилгоос хамааруулан үр дүнд суурилсан явцын болон эцсийн үнэлгээ хийх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөнд ямар төрлийн үнэлгээ хийх талаар нарийвчлан тусгана.

6.3. Хөндлөнгийн үнэлгээг явцын болон эцсийн үнэлгээний аль ч шатанд хийж болох бөгөөд иргэд, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

6.4. Холбогдох бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх үүргийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна. Энэ үүргийг эрүүл мэндийн байгууллагад тэдгээрийн дарга, ерөнхий захирал нар хариуцна.

6.5. Гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв нь тухай жилийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний тайланг энэхүү журмын 7, 8, 9 дүгээр хавсралтын дагуу гаргаж тайланг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ХШУДА-ын нэгж-д журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд хүргүүлнэ.

6.6. Энэхүү журмын 3.1.2-т заасан тусгайлсан хяналт-шинжилгээ, үнэлгээг 2, 3 дугаар хавсралтаар тогтоосон хугацаанд тус тус гаргаж, энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан газарт хүргүүлнэ.

#### Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

7.1. Гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ХШУ-ний нэгж, Эрүүл мэндийн хөгжлийн төв хамтран гүйцэтгэнэ.

7.2. Тусгайлсан хяналт-шинжилгээ, үнэлгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох газар, хэлтэс шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ.

7.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээ, хугацааг удирдамжаар тодорхойлно. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг, удирдамжийг Эрүүл мэндийн сайд эсхүл яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, ажлын

хэсгийн бүрэлдэхүүний 20 хуртэлх хувийг ХШҮ-ний чиглэлээр мэргэшсэн судлаачид, мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдүүлж болно.

7.4. Зайлшгүй шаардлагаар Эрүүл мэндийн сайд болон Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжаар бодлогын тодорхой чиглэлээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж болно.

7.5. Ажлын хэсгийн ажиллах хэлбэр нь хурал байна. Хурлаас тэмдэглэл гарах бөгөөд уг тэмдэглэлд хуралд оролцогчид, гишүүдийн ирц, хэлэлцэх асуудлын агуулга, асуудлыг хэлэлцсэн явц болон хурлаас гарсан шийдвэрийг тус тусган, хуралд оролцсон гишүүдийн гарын үсгийг зурж баталгаажуулна.

7.6. Ажлын хэсгийн хурлыг нийт гишүүдийн дийлэнх олонхи оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцож, ердийн олонхийн саналаар шийдвэр гаргана.

7.7. Тайланд хяналт-шинжилгээ хийхдээ баримт бичиг судлах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

7.8. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгасан тоон болон тоогоор илэрхийлж болох зарим үзүүлэлтийг статистикийн болон тухайн үйл ажиллагааны хүрээний асуудлыг хариуцсан бусад байгууллагын судалгааны үзүүлэлт, тухайн жилд дээд шатны байгууллагаас газар дээр нь хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн зэрэгтэй харьцуулан нягталж үзнэ.

7.9. Жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээ нь шалгуур бүрийн онооны нийлбэрийг нийт шалгуурын тоонд хувааж гаргасан дундаж оноогоор илэрхийлэгдэнэ. Үнэлгээний хувь болон оноог энэхүү журмын 6.17, 6.18-д заасны дагуу тодорхойлно.

7.10. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай тухайн онд байгуулсан Үр дүнгийн гэрээний биелэлтийг Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ыг баримтлан дүгнэнэ.

7.11. Аймаг, нийслэлийн ЭМГ-ын даргын Үр дүнгийн гэрээг дүгнэхдээ аймаг, нийслэлийн Засаг даргаас ЭМГ-ын даргатай байгуулсан Үр дүнгийн гэрээг дүгнэсэн үнэлгээг үндэслэнэ.

7.12. Хэрэглэгчийн үнэлгээг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар тухайн үйлчлэх хүрээний хүн амын насанд хурсэн иргэдийн 3-5 хүртэлх хувийг эсхүүл эрүүл мэндийн байгууллагуудыг хамруулан явуулсан санал асуулгын дүнг үндэслэн гаргах бөгөөд уг үнэлгээг шууд хэрэглэнэ.

7.13. Хэрэглэгчийн үнэлгээг нийслэлд Эрүүл мэндийн хөгжлийн төв, аймагт Эрүүл мэндийн газар хийж гүйцэтгэнэ. Тус төв, газар нь хэрэглэгчийн үнэлгээг судалгааны болон хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг мэргэжлийн болон төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулж судалгааг гүйцэтгүүлж болно.

#### Найм. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

8.1. Хүрэх түвшин нь тодорхойлогдсон шалгуурын гүйцэтгэлийн хувийг гаргахдаа зорилтын гүйцэтгэлийг (Г) хүрэх түвшин буюу тавьсан зорилтод (3)

харьцуулж хувиар илэрхийлнэ ( $\Gamma/3 \times 100$ ). Энэхүү хувийг 0.05-аар үржүүлж ( $\Gamma/3 \times 100 \times 0.05$ ) үнэлгээний оноог тодорхойлно.

8.2. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг дараах аргачлалаар тооцно:

8.2.1. “үр дүнтэй” - зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

8.2.2. “тодорхой үр дүнд хүрсэн” - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь (60-89 хүртэл хувь);

8.2.3. “эрчимжүүлэх шаардлагатай” - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь (31-59 хүртэл хувь);

8.2.4. “үр дүнгүй” - зорилго, зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0 хувь (0-30 хүртэл хувь);

8.2.5. “үнэлэх боломжгүй” - зорилго нь тодорхойгүй, шалгуур үзүүлэлт нь шаардлага хангаагүй, эсхүл шалгуур үзүүлэлттэй боловч гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй, төсөв хөрөнгө тодорхойгүй, гадаад хүчин зүйлээс шалтгаалсан зэргийг баримтаар нотолсон бол.

8.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээг дараах аргачлалаар тооцно:

8.3.1. “бүрэн хэрэгжсэн” - холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

8.3.2. “хэрэгжих шатанд” - тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, хөрөнгө санхүүтэй холбоотой асуудлыг шийдвэрлэсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-89 хүртэл хувь);

8.3.3. “хэрэгжилт хангалтгүй” - тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, хөрөнгөтэй холбоотой асуудал шийдвэрлэгдээгүй бол 30 хувь (10-49 хүртэл хувь);

8.3.4. “хэрэгжээгүй” - тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа, бэлтгэл ажил боловсруулалтын шатанд байгаа, хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь (0-9 хүртэл хувь);

8.3.5. “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”.

8.4. Бодлогын зорилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа арга хэмжээ, зүйл, заалт бүрийн хэрэгжилтийн арифметик дунджаар тооцно. Тавьсан зорилтын арга хэмжээ, шийдвэрийн зүйл, заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулж хувиар илэрхийлнэ.

- B - бодлогын зорилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүн;
- X - арга хэмжээ, зүйл заалтын хүрсэн түвшин;
- Z - арга хэмжээ, зүйл заалтын зорилтот түвшин;
- n - арга хэмжээ, зүйл заалтын тоо;
- i - үзүүлэлтийн дугаар;

$$B = \frac{1}{n} \sum_{j=1}^n \left( \frac{x_j}{z_j} \right) * 100\%$$

8.5. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бусийн оношилгоо, эмчилгээний төвийн тухайн жилийн үйл гүйцэтгэлийн ажиллагааны үнэлгээний дүнг гаргахдаа үзүүлэлт бүрийн үнэлгээг 100 хүртэл хувиар илэрхийлэн нийлбэр үнэлгээний арифметик дундгийг харгалзах жинд шилжүүлнэ. Ерөнхий үнэлгээг тодорхойлоходо жинд шилжүүлсэн дүнгүүдийн нийлбэрийг 0.05-аар үржүүлж, 0-5 хүртэл оноонд шилжүүлэн дүгнэнэ.

E - ерөнхий үнэлгээ;

a - Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчаас төлөөлөн хэрэгжүүлэгч (Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга)-тай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн хувь;

β - эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийн хувь;

γ - хүний нөөцийг чадавхжуулах, тогтвортой суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт;

μ - байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хувь;

s - хэрэглэгчийн үнэлгээ;

n - үр дүнгийн гэрээний арга хэмжээний тоо;

m - шалгуур үзүүлэлтийн тоо;

k - хүний нөөцийг чадавхижуулах арга хэмжээний тоо;

Ω - ил тод байдлын үзүүлэлтийн тоо;

i - үзүүлэлтийн дугаар;

$$E = 0.05 * \left[ \left( \frac{1}{n} \sum_{i=1}^n (\alpha_i) \right) * 0.15 + \left( \frac{1}{m} \sum_{i=1}^m (\beta_i) \right) * 0.35 + \left( \frac{1}{k} \sum_{i=1}^k (\gamma_i) \right) * 0.2 + \left( \frac{1}{\Omega} \sum_{i=1}^{\Omega} (\mu_i) \right) * 0.15 + s * 0.15 \right]$$

8.6. Засгийн газрын гишүүнээс аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, хүний нөөцийг чадавхжуулах, тогтвортой суурьшилтай ажиллуулах зорилтын биелэлт, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт болон байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэхдээ хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээг тооцдог аргачлалыг баримтална.

8.7. Ерөнхий үнэлгээний оноог үндэслэн дор дурьдсан үнэлгээний аль нэгийг өгнө. Үүнд:

"A" буюу "Маш сайн"	90-100 хувь (4.50-5.00 оноо)
"B" буюу "Сайн"	80-89.0 хувь (4.00-4.49 оноо)
"C" буюу "Хангалттай"	70-79.0 хувь (3.50-3.99 оноо)
"D" буюу "Дутагдалтай"	60-69.0 хувь (3.00-3.49 оноо)
"F" буюу "Хангалтгүй"	0-59.0 хувь (0.00-2.99 оноо)

#### Ес. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

9.1. Гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдээс тус бүрд 2 сая хүртэл төгрөгийн мөнгөн урамшуулалт олгоно.

9.2. Тухайн жилд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр "A" буюу "Маш сайн" үнэлгээ авсан эрүүл мэндийн байгууллагын захирагч, даргыг нэг сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн шагналаар урамшуулна. Мөнгөн урамшууллын зардлыг тухайн байгууллагын төсөвт тусгасан байна.

9.3. Энэхүү журмын 9.1-д заасан урамшуулалт шаардагдах хөрөнгийг Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тусган жил бүр батлуулна.

9.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан зөвлөмж, дүгнэлтийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

9.5. Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд тэргүүний арга, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийн хүртээл болгох, гарсан алдаа, дутагдлыг засна.

9.6. Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар үүрэг, чиглэл өгөх, шаардлагатай тохиолдолд зохих удирдамжийн дагуу газар дээр нь хяналт шалгالت хийж, дүгнэлт гаргана.

9.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээг газар дээр нь хийх эрдэмтэн, судлаачдыг үнэлгээ хийхэд татан оролцуулах, хэрэглэгчийн болон хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, сургалт зохион байгуулах, сургалтын материал, ном, товхимол, гарын авлага хэвлүүлэх зэрэг зардлыг өөрийн байгууллагын төсөвт жил бүр тусган батлуулна.

#### Арав. Хариуцлага

10.1. Үнэлгээний дүнгээр "Дутагдалтай" болон "Хангалтгүй" гэж дүгнэгдсэн байгууллагын удирдлагад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

10.2. Энэхүү журмын 3 дах бүлэгт заасныг зөрчиж худал, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан, хугацаанд тайлагнаагүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---оОо---

**ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ  
ТАЙЛАГНАХ ХУГАЦАА**

Нэг. Эрүүл мэндийн байгууллагаас Эрүүл мэндийн яаманд тайлагнах бодлогын баримт бичиг

№	Тайлангийн төрөл	Тайлан хүлээн авах байгууллага, газар	Тайлан ирүүлэх хугацаа (сар, өдөр)	Нэгдсэн тайлан хүлээн авах байгууллага, газар	Тайлан хүлээн авах хугацаа (сар, өдөр)	ЭМЯ-аас тайлагнах	
						байгууллага	хугацаа
Бодлогын баримт бичиг	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого	Эрүүл мэндийн яам, Бодлого төлөвлөлтийн газар	01.10	Эрүүл мэндийн яам, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (ХШУДАГ)	02.01	Засгийн газрын хэрэг эрхлэх газар (ЗГХЭГ)	04.01
	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	Эрүүл мэндийн яам, Төрийн захиргааны удирдлагын газар	01.05 06.05	Эрүүл мэндийн яам, ХШУДАГ	01.10 06.10	ЗГХЭГ	02.01 07.01
	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (Аймаг, нийслэлийн Засаг дарга)	Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн газар болон Эмнэлгийн тусламжийн газар (холбогдох хөтөлбөр )	02.20	Эрүүл мэндийн яам, ХШУДАГ	03.01	ЗГХЭГ	04.01
Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт	Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэр	Эрүүл мэндийн яам, Төрийн захиргааны удирдлагын газар (Хуулийн хэлтэс)	12.20 06.05	Эрүүл мэндийн яам, ХШУДАГ	01.03 06.15	ЗГХЭГ	01.15 07.01
Төсөл	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр	Эрүүл мэндийн яам, Төрийн захиргааны удирдлагын газар (Гадаад)	01.10	Эрүүл мэндийн яам, ХШУДАГ	01.20	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны	03.01

		хамтын ажиллагааны хэлтэс)				төв байгууллага	
Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ	Төсвийн ерөнхийлөн захиргаас Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний биелэлт	Эрүүл мэндийн яам, Төрийн захиргааны удирдлагын газар	01.10 07.20	Эрүүл мэндийн яам, ХШҮДАГ	01.20 08.01	ЗГХЭГ	02.10 08.25
Байгууллагын үйл ажиллагаа	Тухайн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн ХШҮ-ний тайлан	Эрүүл мэндийн яам, ХШҮДАГ	01.10	-	-	-	-

Хоёр. Эрүүл мэндийн яамны газар, хэлтсээс тайлагнах тайлагнах бодлогын баримт бичиг

№	Тайлангийн төрөл	Тайлагнах байгууллага, газар	Нэгдсэн тайлан хүлээн авах байгууллага, газар	Тайлан хүлээн авах хугацаа (сар, өдөр)	ЭМЯ-аас тайлагнах	
					байгууллага	хугацаа
Бодлогын баримт бичиг	Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал	Эрүүл мэндийн яам, Төрийн захиргааны удирдлагын газар	Эрүүл мэндийн яам, ХШҮДАГ	08.10	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	09.01
	Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл	Эрүүл мэндийн яам, Төрийн захиргааны удирдлагын газар	Эрүүл мэндийн яам, ХШҮДАГ	01.03 06.10	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	01.20 06.25
	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	Эрүүл мэндийн яам, Бодлого төлөвлөлтийн газар (Хөрөнгө оруулалтын хэлтэс)	Эрүүл мэндийн яам, ХШҮДАГ	01.10	Үндэсний хөгжлийн газар	02.01

Журмын хоёрдугаар хавсралт

**ХУУЛЬ ТОГТООМИЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

Шийдвэрийн дэс Дугаар	Зүйл, заалтын дэс Дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ (хүчингүй болсон, хянахтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удаширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
			Салбар чиглэл: 1		
			1.а. Монгол Улсын хууль		
			1.б. Улсын Их Хурлын тогтоол		
			1.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол		
			1.г. Ерөнхийлөгчийн зарлиг		
			1.д. Үндэсний агуулгүй байдлын зөвлөлийн зөвлөлж, тэмдэглэл		
			1.е. Засгийн газрын тогтоол		
			1.ё. Ерөнхий сайдын захирамж		
			1.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл		
			1.з. Засгийн газрын албан даалгавар		
			Хэсгийн дундажж.....хувь		
			Салбар чиглэл: 2		
			2.а. Монгол Улсын хууль...		
			Хэсгийн дундажж.....хувь		
			Нийт дундажж.....хувь		

## БОДЛОГЫН БАРИМТ БИЧИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУСНЭГТ

Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, зорилт	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур Үзүүлэлт	Суурь Үзүүлэлт		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл, хувь	Дэлгэрэнгүй тайлбар (Хэрэгжээгүй шалтгаан)										
				ОН	Түвшин				1	2	3	4	5	6	7	8	9	10	
Зорилт 1	Зорилт-1																		
Зорилт 1	Зорилт-1																		
Зорилт 1-ийн хэрэгжицт	Зорилт-1																		
Зорилт 1	Зорилт-1																		
Зорилт 1-ийн хэрэгжицт	Зорилт-1																		
Дүгнэлт. Хэрэгжсэн хувь																			

**ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГДАНЫ ХӨТЕЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУСНЭГТ**

ЗГУАХ-т тусгагдсан, зорилт	Арга хэмжээний дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үсвэр)		Заршиулсан хөрөнгийн хэмжээ, эх үсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, Хүрсэн түвшин, үзүүлэлт үр дүн	
				Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Он		Хүрсэн түвшин, үзүүлэлт үр дүн	
1	2	3	4	5	6	7	8	9

ХӨГЖЛИЙН САЛЬБАР №1.1.

**УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгур үзүүлэлт	Зорилтот түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр	Хүрсэн түвшин, хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1.							
1.1							
1.2							
1.3							
1.4							
1.5							
1.6							
1.7							
1.8							

**ҮНДЭСНИЙ ХӨТЕЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУСНЭГТ**

( ...оны жилийн эцсийн байдлаар )

<b>№</b>	<b>Хөтөлбөр/төслийн агуулга</b>	<b>Гүйцэтгэл</b>
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, оноо, шийдвэрийн дугаар (жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгэн тайлгана)	Төсөл, хөтөлбөрийн зорилго
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв (зээл) буцаалтуйг туслахж
3.	Хэрэгжүүлэч байгууллага/ хэрэгжихийн хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хамгран хэрэгжүүлэгч байгууллага:
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Зорилт 2.
5.	Төсөв (нийт шаардлагах зардал) Үүнд: Багц 1 Багц 2 (г.м.)	Гүйцэтгэл Хувь
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт: 1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1; 2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1; Санамж: Хүрэх гол үр дүнг бичнэ.	Ажлуудын биеэлэлтийг доорх талбарт бичнэ. 1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл 2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл
7.	З-р зорилтынхүрээнд: Хүрэх үр дүн 1;	З-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан
8.	Дүгнэлт (олопт, дутагдал, анхаарах асуудлууд)	Төсөл хэрэгжүүлэхэй холбогдсон олоптой тал, Дутагдалтай талуудыг бичнэ.
	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хамтарч ажилласан талаар энд бичнэ.	Захиалагч талууд, хэрэгжүүлэгч талууд, санхүүжүүлэгч тал, гүйцэтгэч талууд хэрээн

ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ					
Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
9.	...	...	...	...	...
10. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)			Нэгдсэн үнэлгээ	...	...

**ХУНИЙ НӨӨЦИЙГ ЧАДВАЖЖУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН БИЕЛЗЛЭТИЙГ ТАЙЛГАХ ХҮСНЭГТ**

Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зүрүүлгөт түвшин (Тоо хэмжээ, хувь)	Хурсэн түвшин (Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ)	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр (мян.төг)	Тайлбар
1. Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшилүүлэх чиглэлэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	5-аас дээш			
	2	Мэргэшсэн, түршлэгатай хүний нөөцийг буруулжээх үзүүлэлт	Албан хаагчдын хамрагдсан байдал Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал 3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчиний хамрагдсан албан хаагчдынтоо	80 хувиас дээш	20 хувиас дээш	70 хувиас дээш	
<b>Хэсгийн дундаж:</b>							
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдынтоо	Гүйцэтгэлээр			
	4	Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, үр чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шагнал ахлуулж ажлын байрны татай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэлээр			
5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	100 хувь			
		Албан хаагчдын хамрагдлалт					
<b>Хэсгийн дундаж:</b>							
<b>Үнэлгээний дундаж хувь:</b>							

## ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУСНЭГТ

Журмын наймдугаар хавсралт

№	Шалгуйр үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түний ур дун, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартай ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;		
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эзэг /эх/ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцахгүй, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартай ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;		
3.	Үйлчилгээ авахад шаардлагах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартай ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;		
4.	Үйл ажиллагаандын мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартай ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;		
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогоян баримт бичиг болон захирагааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандыа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох териин ба териин бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй тэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;		
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;		
7.	Монгол Улсын Застийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу териин байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үргийг териин бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн териин бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартай ойлгомжтой байдлаар байрлуулсан мэдээлэх;		
8.	Тухайн байгууллага тодорхой териин аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйлажиллага эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн хуудсандыа ойлгомжтой байдлаар байрлуулсан тухай бүр шинэчлэх;		
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, туслаамжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандыа байрлуулсан тухай бүр шинэчлэх;		
Хэсгийн дундаж хувь:			

Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал:

1. Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбаргаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бур шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;
2. Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбаргаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бур шинэчлэх;
3. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бур шинэчлэх;
4. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;
5. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;

Хэсгийн дундаж хувь:

Хэрэгжилтийн дундаж хувь:

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

## Нэг. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар

№	Шалгуур үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Тайлбар
1	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь			
2	Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь			
3	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо			
4	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгэнд хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь			
5	Элэгний хорт хавдрын өвчлөлийн эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтын хувь			
6	Өрхийн, сумын эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн эзлэх хувь			
7	Товтолт дархлаажуулалтын хамралтын хувь (товтолын ангиллаар)			
8	Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь			
9	Нийт төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь			
10	Үүнээс өсвөр насны эмэгтэйн төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь			
11	28-36 долоо хоногтой төрсөн дутуу нярайг амьдруулсан хувь			
12	Төрсний дараах эхний 1 минутад Алгарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь			
13	Төрсний дараах эхний 5 минутад Алгарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь			
14	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)			
15	Нялхсын эндэгдлийн түвшин (1 000 амьд төрөлт тутамд)			
16	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1 000 амьд төрөлт тутамд)			
17	Амьгүй төрөлтийн түвшин, 1000 төрөлтөд			
18	Өсвөр насны 1 000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин			
19	Үр хөндөлтийн түвшин			
20	Өсвөр насны 1 000 эмэгтэйд ногдох үр хөндөлтийн түвшин			
21	Ходоодны шархлаа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)			

22	Даралт ихсэх өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)			
23	Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-44 насны 10 000 хүн амд)			
24	Мухар олгойн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)			
25	Цөсний чулуу, цөсний үрэвслийн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)			
26	Тархинд цус харвалтын нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)			
27	Зүрхний шигдээсийн нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)			
28	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин (10 000 хүн амд)			
29	Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин (10 000 хүн амд)			
30	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин (10 000 хүн амд)			
31	Өсвөр насны 1 000 хүнд ногдох амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин			
32	Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (10 000 хүн амд)			
33	Санамсаргүй хордох, хорт бодист ёртсэнөөс шалтгаалсан нас баралтын түвшин (10 000 хүн амд)			
34	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин (10 000 хүн амд)			
35	Эмчилгээнд орсон халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнөөс эмчилгээний төгсгөлд здгэрсэн хувь			
36	Вируст гепатитын өвчлөлийн түвшин (10 000 хүн амд)			
37	Идэвхтэй илрүүлэлтээр илэрсэн БЗДХ-ын тохиолдлын тоо, Үүнээс эмчилгээнд хамрагдсан хүний тоо			
38	Идэвхтэй илрүүлэлтээр илэрсэн төрөлхийн тэмбүүгийн тоо			
39	Өсвөр насны 1 000 хүнд ногдох БЗДХ-ын түвшин			
40	Бүлэн хайлуулах эмийн хангалтын бэлэн байдал (тромболитик эмийн тоо)			
41	Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсний дараа эсвэл шилжүүлсний дараа 1 сарын дотор нас барсан тохиолдлын хувь (нийт хэвтэн эмчлүүлэгчдийн дотор)			
42	10 000 хүн амд ногдох сувилагчийн тоо			
43	Хүний нөөцийг бүрдүүлэх, 3-5 жилийн төлөвлөлтийн хэрэгжилтийн хувь			
44	Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн тухайн жилийн үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь			

**Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв,  
Бүсийн оношилгоо, эмчилгээний төв**

№	Шалгуур үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Тайлбар
<b>2.1. Нийтлэг үзүүлэлт</b>				
1	Орны фонд ашиглалтын хувь			
2	Дундаж ор хоног			
3	Эмнэлэгт хоног болоогүй нас баралтын хувь (8-24 цагийн дотор)			
4	Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварт гарах урьдчилсан нөхцөлийг илрүүлж зассан тохиолдлын тоо			
5	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь			
6	Задлан шинжилгээний хувь			
7	Үндсэн оношийн зөрүүний хувь			
8	Эрчимт эмчилгээний оронд эмчлүүлсэн хүний тоо			
9	Давтан хагалгааны хувь			
10	Мэс заслын дараах хүндрэлийн хувь			
11	Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсний дараа эсвэл шилжүүлсний дараа 1 сарын дотор нас барсан тохиолдлын хувь (нийт хэвтэн эмчлүүлэгчдийн дотор)			
12	Тухайн мэргэжлийн чиглэлээр явуулсан мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт болон хамрагдагсдын тоо			
13	Тухайн мэргэжлийн чиглэлээр хийж буй: – Судалгаа, эрдэм шинжилгээний хүлээлгэн өгсөн тайлан (үр дүн нь гарсан ажлууд) – Илтгэлийн тоо – Хэвлэгдсэн сэтгүүл болон хэвлэл – Эрдмийн зэрэг хамгаалсан хүний тоо			
14	Нийгэм, хүн амд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийсэн төрөл, хамрагдагсдын тоо			
15	Сэлгэн ажиллуулсан эмч, сувилагчийн тоо (хөдөө орон нутаг болон эмнэлэг хооронд)			
16	Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын үзлэгт хамрагдсан хувь			
17	Хүний нөөцийг бүрдүүлэх, 3-5 жилийн төлөвлөлтийн хэрэгжилтийн хувь			
18	Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн тухайн жилийн үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь			
<b>2.2. Өвөрмөц үзүүлэлт</b>				
<b>2.2.1. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв</b>				
1	Эмчилгээ, оношилгоо, сувилахуйн тусламж үйлчилгээнд шинэ арга технологи нэвтрүүлсэн тоо, шинэ санаачлага			
2	Бүлэн хайлуулах эмийн хангалтын бэлэн байдал (тромболитик эмийн тоо)			
3	Эмнэлгээр үйлчилүүлэх үедээ унаж, гэмтсэн тохиолдлын тоо			
4	Ходоодны шархлаа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)			
5	Даралт ихсэх өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)			
6	Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-44 насны 10 000 хүн амд)			

7	Мухар олгойн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насы 10 000 хүн амд)			
8	Цөсний чулуу, цөсний үрэвслийн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насы 10 000 хүн амд)			
9	Тархинд цус харвалтын нас баралтын түвшин (0-74 насы 10 000 хүн амд)			
10	Зүрхний шигдээсийн нас баралтын түвшин (0-74 насы 10 000 хүн амд)			

#### 2.2.2. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв

#### Хавдар судлалын үндэсний төв

1	Хорт хавдар анх оношлогдож, эмчлэгдсэнээс хойш 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь (үндэсний хэмжээнд)			
2	Хорт хавdryн шалтгаант нас баралтын түвшин (10 000 хүн амд)			
3	Улсын хэмжээнд анх оношлогдсон хорт хавдар, үе шатаар			
4	Төвийн хэмжээнд анх оношлогдсон хорт хавдар, үе шатаар			
5	Улсын хэмжээнд хөнгөвчлөх тусlamж, үйлчилгээ авсан нийт хүний тоо			
6	Хими эмчилгээний хүлээгдлийн дундаж хугацаа			
7	Туяа эмчилгээний хүлээгдлийн дундаж хугацаа			
8	Хөнгөвчлөх эмчилгээний хүлээгдлийн дундаж хугацаа			

#### Халдварт өвчин судлалын үндэсний төв

1	Шинээр илэрсэн сурьеэгийн нийт тохиолдлоос ДОТС эмчилгээг бүрэн хийлгэсэн хувь			
2	ДОТС эмчилгээнд хамрагдагсдын эдгэрэлтийн хувь			
3	Олон эмэнд тэсвэртэй сурьеэтэй өвчтөний эмчилгээний амжилтын хувь			
4	Эмчилгээнд орсон халдвартай хэлбэрийн сурьеэтэй өвчтөнөөс эмчилгээний төгсгөлд эдгэрсэн хувь			
5	Улаанбаатар хотод сурьеэтэй өвчтөнд шууд хяналттай эмчилгээ хийж буй өрхийн эмнэлгийн хувь			
6	Вирусийн эсрэг эмчилгээнд хамруулсан архаг вируст хепатит өвчтэй эмчилүүлэгчийн тоо			
7	Идэвхтэй илрүүлэлтээр илэрсэн БЗДХ-ын тохиолдлын тоо			
8	Идэвхтэй илрүүлэлтээр илэрсэн төрөлхийн тэмбүүгийн тоо			
9	БЗДХ-ын лабораторийн оношилгооны чанарын гадаад хяналтын үнэлгээний хувь (80-иас дээш ХӨСҮТ-ийн хэмжээнд)			
10	PBЭЭ эхлэх шаардлага хангасан ХДХВ/ДОХ-той хүмүүсээс эмчилгээ хийлгэж буй хүний хувь			
11	Эмчилгээ шаардлагатай ХДХВ-ийн халдвартай хүмүүсээс ретровирусын эсрэг эмчилгээний хамрагдалтын хувь (үндэсний хэмжээнд)			

#### Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

1	Дутуу төрөлтийн түвшин (37 долоо хоногоос бага), 1000 амьд төрөлтөд			
2	Амьгүй төрөлтийн түвшин, 1000 төрөлтөд			
3	Нийт төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь			
4	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд – төвийн хэмжээнд)			
5	28-36 долоо хоногтой төрсөн дутуу нярайг амьдруулсан хувь			
6	Төрсний дараах эхний 1 минутад Апгарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь			

7	Төрсний дараах эхний 5 минутад Апгарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь			
8	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд - төвийн хэмжээнд)			
9	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд) - төвийн хэмжээнд			
10	Цусны хорт хавдар анх оношлогдоноос хойш 10-аас дээш жил амьдарсан хүүхдийн эзлэх хувь			
11	Цусны эргэлтийн тогтолцооны төрөлхийн гажгийн шалтгаант нас баралтын түвшин (0-16 насны 10 000 хүн амд)			
12	Уушгини хатгалгаа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-16 насны 10 000 хүн амд)			
13	Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-16 насны 10 000 хүн амд)			
14	Мухар олгойн шалтгаант нас баралтын түвшин (0-16 насны 10 000 хүн амд)			
15	Цөсний үрэвслийн шалтгаант нас баралтын түвшин (0-16 насны 10 000 хүн амд)			

#### Арьсны өвчин судлалын үндэсний төв

1	Хяналтад байгаа арьсны архаг, удаан хугацааны нөхөн сэргээх эмчилгээ шаардаг өвчний намжмал үеийн дундаж хугацаа			
2	Арьсны хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)			
3	Арьсны эдийн шинжилгээгээр оношийн баталгаажилтын хувь			
4	Арьсны архаг өвчтэй өвчтөнүүдийн нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдсан хувь			
5	Хордлого харшлын дерматит, Лайлын хам шинж өвчний шалтгаант нас баралтын түвшин (10 000 хүн амд-үндэсний хэмжээнд)			
6	Ховор тохиолддог арьсны өвчний оношилгооны хувь			
7	Анафилаксийн шокийн шалтгаант нас баралтын түвшин (10 000 хүн амд-үндэсний хэмжээнд)			
8	Харшлын аллерген эмчилгээнд хамрагдагсдын тоо			
9	Эрт илрүүлэлтээр илэрсэн:			
	– Ургамлын харшлын эмгэгийн тоо			
	– Хоол хүнсний харшлын эмгэгийн тоо			

#### Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

1	Шинээр оношлогдсон өвчтөнг идэвхитэй хяналтад авсан хувь			
2	Сэтгэцийн эмгэгтэй нийт өвчтөнүүдээс нийгэм, сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдсан хувь			
3	Архинаас гарах эмчилгээнд хамрагдсан хүний тоо			
4	Шинээр бүртгэгдсэн сэтгэцийн өвчлөл (10 000 хүн амд-үндэсний хэмжээнд)			
5	Мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэх эмгэгийн эмчилгээний хамралтын хувь			
6	Мансууралт, донтолтоос сэргийлэх үйл ажиллагаа явуулсан хэлбэр, хамрагдалтын хувь (үндэсний хэмжээнд)			
7	Энхжин –шинэ арга, тест			

#### Гэмтэл согог судлалын үндэсний төв

1	Осол, гэмтлээс шалтгаалсан өвчлөл (10 000 хүн амд - үндэсний хэмжээнд)			
2	Осол, гэмтлээс шалтгаалсан нас баралт (10 000 хүн амд - үндэсний хэмжээнд)			

3	Түнхний үе солих мэс заслын тоо			
4	Өвдөгний үе солих мэс заслын тоо			
5	Түлэнхий өвчний эдгэрэлтийн хувь			
6	Түлэнхий өвчний нас баралтын хувь			

**Цус сэлбэлт судлалын үндэсний төв**

1	Тухайн жилд шинээр бүртгэгдсэн донорын тоо			
2	Бүртгэлтэй донорын тоо, үүнээс байнгын донорын эзлэх хувь			
3	Тухайн жилийн цус өгөлтийн тоо, өсөлт			
4	Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тоо хэмжээний өсөлт, нэр төрлөөр (нэгжээр)			
5	Тайван, онцгой байдлын үеийн нөөцийн бурдуулэлтийн хэмжээ (нэгжээр)			
6	Цус, цусан бүтээгдэхүүний хангалтын хувь			
7	Цус сэлбэлтийн хундрэлийн хувь (үндэсний хэмжээнд)			

**Эмгэг судлалын үндэсний төв**

1	Задлан шинжилгээний хувь (үндэсний хэмжээнд)			
2	Үндсэн оношийн зөрүүний хувь (үндэсний хэмжээнд)			
3	Хундрэлийн зөрүүний хувь (үндэсний хэмжээнд)			
4	Эдийн шинжилгээний тоо хэмжээний өсөлт			
5	Эсийн шинжилгээний тоо хэмжээний өсөлт			
6	Эмнэлгийн нас баралтад зайлшгүй хийгдвл зохих эмгэг судлалын задлан шинжилгээний гүйцэтгэлийн хувь			
7	Эмнэлэг буюу эрүүл мэндийн байгууллагад эмгэг судлалын тусlamж, үйлчилгээтэй холбоотой төлөвлөгөөт гадаад хяналтын гүйцэтгэлийн хувь			
8	Үндсэн оношийн зөрүүг зөв тогтоож, эмчилгээ, үйлчилгээний дутагдалтай тохиолдолд эмнэлзүй, эмгэг судлалын зөвлөгөөн хийсэн тоо			
9	Эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлж буй байгууллагын эмгэг судлалын тусlamж, үйлчилгээний төлөвлөгөөнд хийсэн үнэлгээний гүйцэтгэлийн хувь			
10	Нийт нас баралтад эмнэлзүй эмгэг судлалын зөвлөгөөний эзлэх хувь			

**Зоонозын өвчин судлалын үндэсний төв**

1	Идэвхтэй тандалтаар шинээр илрүүлсэн голомтын тоо			
2	Тухайн жилд төлөвлөгдсэн тандалтын гүйцэтгэлийн хувь			
3	Хүн амын дундах зоонозын өвчний халдварталтын хувь			
4	Зоонозын халдварт өвчний өвчлөл (10 000 хүн амд)			
5	Лабораторийн оношийг баталгаажуулсан хувь			
6	Эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулалтад хамруулсан хувь (нэр төрлөөр)			
7	Үндэсний хэмжээнд байгууллага, аж ахуйн нэгж, ажилтнуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн байдал (давтамж, тоо)			
8	Зоонозын халдвартын хүний өвчлөлийн дэгдэлтийн үед хийсэн эрсдэлийн үнэлгээ			
9	Зоонозын халдварт өвчний дуудлагад цаг хугацаандаа үйлчилсэн байдал			
10	Зоонозын халдвартын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлыг лабораторийн шинжилгээнд хамруулсан хувь			
11	Эерэг сорьцын баталгаажилт			
12	Захиалгат тэжээлт орчин, биобэлдмэл, будаг, урвалжийн нийлүүлэлт			

### Геронтологийн үндэсний төв

1	Гэрийн тусламж авсан настны тоо (эрүүл мэндийн 4, 5-р бүлгийн ахмад настан)			
2	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан настны тоо			
3	Эрүүл мэндийн бүлэг шилжсэн ахмадын тоо			
4	Геронтологи, гериатрийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтний тоо (их эмч, сувилагч)			
5	Геронтологи, гериатрийн чиглэлээр сургалтанд хамруулсан хүний тоо (настан, сайн дурын идэвхтэн, асран хамгаалагч, эмнэлгийн мэргэжилтэн)			
6	Ахмад настангуудыг хийн дасгал хөдөлгөөнд хамруулсан хувь, үр дүнг тооцсон эсэх			
7	Бие даах чадварын үнэлгээ хийсэн ахмад настны тоо			

### Хүүхдийн төв сувилал

1	Цус багадалтай хүүхдийн сайжирсан хувь			
2	Сульдаа өвчтэй хүүхдийн сайжирсан хувь			
3	Тураалтай хүүхдүүдээс жингийн алдагдал буурсан хүүхдийн тоо, хувь			
4	Бага жинтэй нярайг торниулсан тоо, хувь			
5	Сэргээн засах эмчилгээний сайжирсан хувь			
6	2 буюу түүнээс дээш ихрийг авч сувилан, сайжруулсан хувь			
7	Өдрөөр сувилуулсан хүүхдийн тоо			

### Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

1	Тухайн жилд хийгдсэн тандалт, судалгааны тоо			
2	Шинээр хийгдсэн биобэлдмэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүний тоо			
3	Олон улсын чанарын баталгаажилтад хамрагдсан лавлагаа лабораторийн тоо			
4	Эрүүл мэндийн нелөөллийн үнэлгээ хийсэн тоо, үр дүн			
5	Осол гэмтлийн тохиолдлын түвшин (10 000 хүн амд)			
6	Зүрх судасны өвчлөлийн түвшин (10 000 хүн амд)			
7	Тархинд цус харвалт өвчний өвчлөлийн түвшин (10000 хүн амд)			
8	Чихрийн шижин өвчний өвчлөлийн түвшин (10000 хүн амд)			
9	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамрагдалтын хувь			
10	Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн хамрагдалтын хувь			
11	Бага жинтэй төрсөн хүүхдийн хувь			
12	Тураалтай хүүхдийн эзлэх хувь			
13	Өсөлтийн хоцрогдолтой хүүхдийн эзлэх хувь			
14	Туранхай хүүхдийн эзлэх хувь			

### Эрүүл мэндийн хөгжлийн төв

1	Тухайн жилд хийгдсэн судалгааны тоо			
2	Төрийн захиргааны төв байгууллагыг нотолгоонд тулгуурласан мэдээллээр хангаж, түүнийг шийдвэр гаргалтад ашигласан байдал			
3	Өвчний олон улсын ангиллын хэрэглээг сайжруулахаар зохион байгуулсан арга хэмжээний тоо			
4	Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд зохион байгуулсан сургалтын тоо			
5	Телемедицин ашиглаж авсан оношилгоо, эмчилгээний зөвлөгөөний хувь			
6	Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой нотлогдсон гомдлын тоо (дотоод болон гадаадын эмнэлгийн мэргэжилтэн)			

7	Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалттай холбоотой нотлогдсон гомдлын тоо			
8	Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагаатай холбоотой нотлогдсон гомдлын тоо			
9	Мэргэшүүлэх сургалт удирдах эмнэлзүйн сургагч багш бэлтгэх 3-5 жилийн төлөвлөлт, түүний хэрэгжилт			
10	Эрүүл мэндийн ажилтны мэдээний нэгдсэн сангийн баяжилт, тогтвортой үйл ажиллагаа			
11	Явцын үнэлгээ хийж, зөвлөмж өгсөн сургалт эрхлэх байгууллагын тоо			
12	Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийн мэдээний сангийн баяжилт, тогтвортой үйл ажиллагаа			
13	Эм, биобэлдмэл, вакциныг улсын бүртгэлд бүртгэсний дараах хийсэн тандалт судалгааны хувь			
14	Эмийн зар сурталчилгааны тоо			
15	Тухайн жилд бүртгэгдсэн нийт эмнээс эмийн хэрэглэх зааврыг баталгаажуулсан хувь			
16	Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулах арга, хэрэгслийг нэвтрүүлсэн тоо, түүний хэрэгжилтэд хийсэн хяналт			
17	Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагуудад явцын хяналт хийж, зөвлөмж өгсөн байгууллагын тоо			
18	Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан эмнэлгийн тусlamж, үйлчилгээтэй холбоотой мэдээллийг алдаа, зөрчлийн мэдээллийн санд бүртгэгдсэн хувь			

--- ОOO ---